

2024 оны 11 сарын 19-ны өдөр

№ 18

Улаанбаатар хот

Салбар нэгж шинээр байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.25 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.6.9 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэх борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор Чингис хаан ОУНБ-д салбар нэгж шинээр байгуулсугай.
2. Шинээр байгуулах салбар нэгжийн хаягийг Монгол Улс, Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ уул 4-р баг, Тахилт толгой, НУБИЭ ХХК-ийн Зорчигч терминалын барилга 2 давхарт С/С 305-1А тоот байхаар тогтоосугай.
3. Компанийн дүрэмд заасны дагуу салбар нэгжийн удирдлагыг томилохыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.
4. Салбар нэгжийг шинээр байгуулахтай холбоотойгоор түрээсийн гэрээ байгуулах, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ



Handwritten signature of B. Narantsetseg, the Chairman of the Board of Directors, over a blue circular official stamp of SANDLI Bank.

20²⁴ оны 11 сарын 19 ны өдөр

№ 29

Улаанбаатар хот

*Арилжааны банкинд зээлийн шугамын эрх
нээлгэх тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдад зээл олгох, зээлийн эрэлтийг хэвийн хадгалах, бизнес төлөвлөгөөний хүрээнд “Сэндли ББСБ” ХК-ийн нэр дээр Капитрон банканд дараах нөхцөлөөр зээлийн шугамын эрх нээлгэхээр тогтсугай.

Зээлийн эрхийн хэмжээ: 2,000,000,000 /хоёр тэрбум/ төгрөг

Зээлийн эрхийн хугацаа: 24 /хорин дөрвөн/ сар

Зээлийн хүүгийн хэмжээ: сарын 1.8 /нэг аравны найман/ хувь

2. Энэхүү тогтоолын 1-д заасан “Сэндли ББСБ” ХК-ийн зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 5 /таван/ тэрбум төгрөгийн дүн бүхий хэрэглээний, үл хөдлөх хөрөнгө болон автомашин барьцаалсан зээлийн багцийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
3. Банктай зээлийн болон барьцааны гэрээ байгуулах, гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Үйл ажиллагаа хариуцсан захирал /Б.Ичинхорлоо/ нарт олгосугай.
4. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж ажиллахыг Эрсдэл хяналт, шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ


